**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ**
**БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ**
**ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 15 өдөр Дугаар А/61 Арвайхээр

# Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.6 дахь заалт, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/514 дугаартай "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө батлах тухай" тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаартай "Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай" тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаартай "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах зарим арга хэмжээний тухай" тушаал, Монгол Улсын "Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх удирдамж" MNS ISO/TS 9002:2020 стандарт, Америкийн зүрх судасны нийгэмлэгийн "Амилуулах лавшруулсан тусламж үзүүлэх 2016, 2020" удирдамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн орчинд зүрх, амьсгалын үйл ажиллагаа нь зогссон үйлчлүүлэгчид үзүүлэх амилуулах тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлж буй "Амилуулах лавшруулсан тусламж үйлчилгээ үзүүлэх "Code blue" дохиоллын системийг идэвхжүүлэх" журмыг нэгдүгээр хавсралтаар, Амилуулах лавшруулсан тусламжийн бүртгэл, Амилуулах тэргэнцэрт байх шаардлагатай эм хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, "Code blue" дохиоллын системийн үйл ажиллагааны зураглалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа), "Code blue" идэвхжүүлсэн тохиолдолд тухайн өдрийн жижүүр эмч, яаралтай тусламж эрчимт эмчилгээний сувилагч, код зарласан тухайн тасгийн сувилагч, тасгийн эрхлэгч, сувилахуйн арга зүйч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тусламж үйлчилгээний биелэлтийг улирал тутам тооцож ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга (Ц.Лувсандамдин), Эмнэлзүйн эрсдэл хариуцсан Чанарын менежер (Л.Золзаяа), Чанарын менежер (Ж.Нарантуяа) нарт тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ Г.ДАШЖАНЦАН

6218270659
ТУЗ1336 9045295

D.doc.tushaal-2023 on